

2024

ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

*Эх дэлхийгээ хайрлаж
Эрцм амьдралыг хамтдаа бүтээнэ*

АГУУЛГА

Компанийн түүхэн товчоо

2

Эрхэм зорилго, Алсын хараа, Үнэт зүйлс

4

Онцлох үйл явдлууд

5

Хувьцааны мэдээлэл

7

Санхүүгийн тайлан, мэдээлэл

8

Голлох үзүүлэлтүүд

10

Шинэ болон шинэчлэгдсэн бүтээгдэхүүн

11

Эрүүл мэндийн хүнсний үйлдвэр

12

ESG | Байгаль орчин, нийгэм, засаглал

13

2012

Монос Фарм ХХК-аас өрх тусгаарлаж, Монос Хүнс ХХК албан ёсоор үүсгэн байгуулагдав. Эрүүл мэндийн ус, ундааны цехийг ашиглалтад оруулав.



2013

Шилэн савлагаатай Цэнэг эрүүл мэндийн бэлдмэлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэв.



2015

Монгол Улсад анх удаа эрүүл мэндийг дэмжсэн үйлдэлтэй Монголчуудын хооллолтын онцлог дээр тулгуурлан хүчил шүлтийн харьцааг тэнцвэржүүлэх Экос pH8.5 зөөлөн шүлтлэг усыг үйлдвэрлэв.



2014

ODOO ERP /Enterprise Resource Planning/ системийг компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэв.



2016

Монгол Улсад анх удаа уусдаг цайны төрөлд импортийг орлох аньс, нэрс, чацаргана жимстэй өнгө үнэр амт орлуулагч ашиглаагүй Эко уусдаг цайг үйлдвэрлэж эхлэв.



2017

Чанарын удирдлагын тогтолцоо болох ISO9001:2015 болон Хүнсний аюулгүй байдлын HACCP стандартыг нэвтрүүлэх төслийн ажил эхлэв.



2018

Өтгөрүүлсэн Барагшун бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж эхлэв. Монос Хүнс компани биет бус хөрөнгөө үнэлүүлсэн Монголын анхны компани болов.



2019

Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан IPO хийж нээлттэй Хувьцаат Компани болов. Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 болон Хүнсний аюулгүй байдлын HACCP стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж Олон улсын аудитын SGS компаниар баталгаажуулж гэрчилгээгээ гардан авав.



IPO

2020

Хүнсний үйлдвэрийн нэгдсэн удирдлагын тогтолцоо болох ISO22000:2018 болон Хүний нөөцийн менежментийн ISO:30400 стандартыг нэвтрүүлэх төслийг эхлүүлэв. Эрүүл Мэндийн Шингэн хүнсний үйлдвэрийг ашиглалтад оруулан, 8 нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв.



2021

Vitos брэндийн Цэнэг эрүүл мэндийн бэлдмэлийг шинэчлэн зах зээлд амжилттай байршуулав. Мөн тус брэндийн "Shot" 3 нэр төрлийн биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргалаа.



2022

"Монос Хүнс" ХК нь Австри улсад төвтэй "TSC" /The chilled Snack Company/ компанийн ОХУ дахь салбар "TSC Food Products Ru" компанитай хамтран ажиллаж Милено брэндийн Творожное Драже үрлийг тус улсын зах зээлд амжилттай гаргалаа. Тус бүтээгдэхүүнийг Киргиз болон Евразийн 5 улсад гаргах боломж бүрдлээ.



2023

Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс ХК, Монгол эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд анхаарал хандуулж "Хэнэгтэй Монгол Эр хүн" төслийг амжилттай эхлүүлж эрэгтэйчүүдийн тухай хэвшмэл ойлголтыг халах, өөрчлөх нийгмийн нөлөөллийн төслийг амжилттай хэрэгжүүлж давхардсан тоогоор 22 сая хүнд хүргэж чадлаа.

Мөн 2023 онд Бүгд Найрамдах Киргиз улсын эм ханган нийлүүлэх Лекарь компаниар дамжуулан 20 нэр төрлийн бүтээгдэхүүнээ албан ёсны эрхтэйгээр тус улсад худалдан борлуулахаар боллоо.



2024

Монос Хүнс ХК үйл ажиллагаагаа Швейцар улсад төвтэй дэлхийд тэргүүлэгч аудитын SGS компанийн 2 үе шаттай өндөр шалгуураар шалгуулж ISO 9001:2015, FSSC 22000:2018, ISO 14001:2015 стандартуудыг амжилттай хэрэгжүүлж буйгаа баталгаажуулж олон улсад дахин хүлээн зөвшөөрөгдлөө.



МОНОС
ХҮ-С

Лекарь
Киргиз Республикасынын



АЛСЫН ХАРАА:

Эх дэлхийгээ хайрлаж
Эрүүл амьдралыг хамтдаа бүтээнэ



ЭРХЭМ ЗОРИЛГО:

Хүрээлэн буй орчин, оролцогч талуудаа хүндэлсэн, эрүүл амьдралын хэв маягийг дэлгэрүүлэгч, үнэ цэн бүтээгч компани байна.



ҮНЭТ ЗҮЙЛ:



Оролцогч талууд



Эерэг соёл



Инновацлаг бүтээгдэхүүн

Монос Хүнс ХК-ийн үйл ажиллагаа олон улсад дахин хүлээн зөвшөөрөгдлөө

Монос Хүнс ХК нь 2017 оноос эхлэн Олон улсын Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015, Хүнсний аюулгүй байдлын тогтолцоо FSSC 22000:2018, 2022 оноос Байгаль орчны чанарын удирдлагын тогтолцооны ISO 14001:2015 стандартуудыг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү стандартуудын хэрэгжилтийг Швейцар улсад төвтэй, дэлхийд тэргүүлэгч аудитын SGS компанийн хамт олон 2024.02.26-2024.03.07-ны хооронд 2 үе шаттай өндөр шалгуураар хянан, амжилттай хэрэгжүүлж буйг баталгаажуулж гэрчилгээг 2024.06.21-ны өдөр SGS компанийн Шанхай хот дахь төлөөлөгчийн газрын бус хариуцсан захирал ноён Cliff Zheng Гүйцэтгэх захирал А.Отгондарь тэргүүтэй төлөөллүүдэд гардуулж өглөө.



Монос Хүнс ХК “Дэлхийн бөөр хамгаалах өдөр”-өөр УХТЭ-тэй хамтран ажиллалаа

Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс ХК дэлхийн бөөр хамгаалах өдрийг тохиолдуулан Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаториор үйлчлүүлж буй хүмүүст бөөрний өвчлөл, түүнээс урьдчилан сэргийлэх, бөөр хамгаалах үйлдэлтэй бүтээгдэхүүнийг хэрэглэх ач тусын талаар тус эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдтэй хамтран эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл өгөх өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа.



"00:20 ЖИЛ" хүүхдийн сэтгэл зүйг дэмжих ажлыг BERRYVIT брэндийн зүгээс эхлүүлээ

Хүүхэдтэйгээ ярилцах, тэдэнтэй хамт тоглох, тэднийг сонсох, сонирхож байгаа зүйлсийг дэмжиж, шинэ зүйлсийг зааж өгөх 20 минутын чанартай цагийг хүүхдүүддээ зориулахыг уриалсан "00:20 ЖИЛ" хүүхдийн сэтгэл зүйг дэмжих ажлыг BERRYVIT брэндийн зүгээс эхлүүллээ. Энэхүү уриалгын хүрээнд хүүхдэдээ үлгэр жишээ чанартай цагаа зориулдаг эцэг эхчүүдийн сайн туршлагаас хуваалцах, хүүхдийн сэтгэлзүйчийн зөвлөгөө контентыг BERRYVIT брэндийн албан ёсны хуудаснаас хүргэн ажиллаж байна.



Монос Хүнс ХК бүтээгдэхүүнээ Киргиз улсад албан ёсоор худалдаалж эхэллээ

Монос Групп Бүгд Найрамдах Киргиз улсад бүтээгдэхүүнээ худалдаалах албан ёсны нээлтээ 2024 оны дөрөвдүгээр сарын 16-ны өдөр хийж хэрэглэгч, тус улс дахь албан ёсны төлөөлөгч болон борлуулагч компанийн 200 гаруй харилцагчдад зориулж маркетингийн идэвхжүүлэлтийн арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Энэхүү үйл ажиллагаанд экспортын 20 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээ танилцуулахын зэрэгцээ зах зээлийн судалгаа, шинжилгээ хийх, тус улсын топ сүлжээ дэлгүүр, хүндэт зочидтой харилцаа холбоо тогтоосон тэмдэглэлт өдөр болж өнгөрлөө. Монос Хүнс ХК болон Монос Косметик ХХК эрүүл мэнд, гоо сайхны бүтээгдэхүүнээ энэ оны хоёрдугаар сараас Киргиз улсад худалдаалж эхэлсэн бөгөөд эхний хагас жилд Киргиз улсруу 30,000\$-ын экспорт хийж өнөөдрийн байдлаар Бишкек хотын Лекарь сүлжээ эмийн сангийн 100 гаруй салбараар амжилттай борлуулж байна.



Монос Хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчид ойрын ирээдүйд томоохон өгөөжөө өгөх MFC 2.0 үйлдвэртэй танилцлаа

Монос Хүнс ХК нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр шинээр ашиглалтад ороод байгаа Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрийн байртаа танхимаар болон хүртээмжтэй байдлыг хангах үүднээс цахимаар зохион байгууллаа. Нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 75%-ийн ирцтэй хуралдсан энэ удаагийн хурал шинээр ашиглалтад ороод буй Монос Хүнс ХК-ийн Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрийн хурлын танхимд болсноороо онцлог боллоо. Хурлын дараа хувьцаа эзэмшигчид шингэн хүнс болон хуурай хүнсний үйлдвэрүүдээр орж компанийн ойрын ирээдүйд томоохон өгөөжөө өгөх MFC 2.0 төслийн бүтээн байгуулалт, ашиглалтад ороод байгаа шинэ үйлдвэр, оффистой биечлэн танилцсан юм.



"Хэнэгтэй Монгол Эр хүн" төсөл "Social impact 2024" арга хэмжээнд урилгаар оролцож туршлагаасаа хуваалцлаа

Монос Хүнс ХК "Social impact 2024" арга хэмжээнд урилгаар оролцож "Хэнэгтэй Монгол Эр хүн" нийгмийн нөлөөллийн төслийнхөө сайн туршлагаас хуваалцлаа. Монгол болон Олон улсад амжилттай хэрэгжиж үр дүнгээ өгөөд байгаа нийгмийн маркетингийн жишиг кампанит ажлын туршлагаас хуваалцаж, хэрхэн амжилттай зохион байгуулах тухай илтгэл, хэлэлцүүлэг өрнүүлсэн "Social impact 2024" үзэсгэлэн, өдөрлөгт Монос Хүнс ХК-ийг төлөөлж Маркетингийн албаны дарга Б.Дуламсүрэн төслийнхөө бэлтгэл ажил, судалгаа шинжилгээ, ач холбогдол, үр дүнгийн талаар арга хэмжээнд оролцогч 100 гаруй салбарын мэргэжилтнүүдэд танилцуулсан юм.



Монос Хүнс ХК "Monos Care" аяны хүрээнд хэрэглэсэн таягаа бусдадаа хандивлах цэгийг дахин нэг эмнэлэгт амжилттай байршууллаа

Монос Хүнс ХК "Monos Care" аяны хүрээнд 2019 онд хэрэглэсэн таягаа уул овоонд үлдээж байгаль орчиндоо хог хаягдлыг бий болгодог жишгийг өөрчилж бусдадаа хэрэгтэй зүйлээ хуваалцах дадлыг бий болгохыг уриалж ГССҮТ-д ТАЯГ хандивлах цэгийг амжилттай нутагшуулсан билээ. Тэгвэл 2024 онд Гэмтэл согогийн томоохон хувийн хэвшлийн эмнэлэг "Мөнгөн гүүр" эмнэлэгтэй хамтран тус эмнэлэгт "Таяг хандивлах цэг"-ийг бий болголоо.



Сувиллын идэвхжүүлэлт арга хэмжээ зохион байгуулагдлаа

Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс ХК-аас жил бүр ахмадууддаа чиглэсэн ажлууд зохион байгуулдаг бөгөөд "Эрдэнэт хүн таны эрүүл биеийн төлөө-2024" уриан дор сувиллын идэвхжүүлэлт арга хэмжээгээ эхлүүллээ. Тус арга хэмжээ Сүүж-Уул, Төгөл болон Оргил рашаан сувиллаар зохион байгуулагдав. Энэ үеэр нийт 400 гаруй амрагч, ажилтан хамрагдсан бөгөөд нийгэмд зонхилон тохиолдох өвчлөл, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар эмч, мэргэжилтнүүд эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл хүргэлээ. Түүнчлэн Монос Хүнс ХК-ийн эрүүл мэндийг дэмжих хүнсний бүтээгдэхүүнүүдийг танилцуулсан юм.



ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

MONOS

MSE: MFC



2021.12.31-ны
хаалтын ханш: **113.2₮**

2022.12.31-ны
хаалтын ханш: **124.7₮**

2023.12.31-ний
хаалтын ханш: **99.9₮**

Хамгийн доод
ханш: 2024 он **83.6₮**

Хамгийн дээд
ханш: 2024 он **104.7₮**

2024.06.27-ны
хаалтын ханш: **93.7₮**

САНХҮҮГИЙН ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ

Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2023.H1	2024.H1
Эргэлтийн харьцаа / Current Ratio	1.2	2.4
Түргэн хөрвөх харьцаа / Quick Ratio	0.6	1.8
Бие даалтын коэффициент / Shareholder Equity ratio	41%	38%
Өрийн харьцаа / Debt ratio	59%	62%
Нийт ашгийн хувь / Gross profit margin	47.3%	47.4%
Цэвэр ашгийн хувь / Net income margin	12.7%	8.3%
Нийт хөрөнгийн өгөөж / Return on Assets - ROA	4.6%	2.4%
Өөрийн хөрөнгийн өгөөж / Return on Equity - ROE	11.4%	6.2%

САНХҮҮГИЙН ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ

Санхүү байдлын тайлан

Үзүүлэлт /сая.төг/	2023.Н1	2024.Н1	Өөрчлөлт %	Нийт хөрөнгөд эзлэх %	
				2023.Н1	2024.Н1
ХӨРӨНГӨ	45,287.6	60,799.4	34%	100%	100%
Эргэлтийн хөрөнгө	13,729.1	25,756.5	88%	30%	42%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	586.3	6,746.5	1051%	1%	11%
Дансны авлага	5,309.3	5,536.3	4%	12%	9%
Татвар, НДШ - ийн авлага	1,285.6	1,921.6	49%	3%	3%
Бусад авлага	145.4	224.1	54%	0%	0%
Бараа материал	6,250.7	6,831.7	9%	14%	11%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	151.8	412.1	172%	0%	1%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	0.0	4,084.2		0%	7%
Эргэлтийн бус хөрөнгө	31,558.5	35,042.9	11%	70%	58%
Үндсэн хөрөнгө	30,004.4	34,184.6	14%	66%	56%
Биет бус хөрөнгө	469.3	377.5	-20%	1%	1%
Хойшлогдсон татварын хөрөнгө	70.2	98.7	41%	0%	0%
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,014.6	382.0	-62%	2%	1%
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	45,287.6	60,799.4	34%	100%	100%
Өр төлбөр	26,889.4	37,433.3	39%	59%	62%
Богино хугацаат өр төлбөр	11,846.6	10,683.8	-10%	26%	18%
Дансны өглөг	914.2	1,679.0	84%	2%	3%
Цалингийн өглөг	179.0	133.0	-26%	0%	0%
Татварын өр	1,547.7	614.6	-60%	3%	1%
НДШ-ийн өглөг	140.2	189.9	35%	0%	0%
Богино хугацаат зээл	7,260.0	7,090.0	-2%	16%	12%
Зээлийн хүүгийн өглөг	227.2	68.1	-70%	1%	0%
Ногдол ашгийн өглөг	981.2	0.0	-100%	2%	0%
Урьдчилж орсон орлого	40.9	104.0	155%	0%	0%
Нөөц өр төлбөр	211.0	211.0	0%	0%	0%
Бусад богино хугацаат өр төлбөр	345.4	594.2	72%	1%	1%






САНХҮҮГИЙН ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ

Санхүү байдлын тайлан

Үзүүлэлт /сая.төг/	2023.Н1	2024.Н1	Өөрчлөлт %	Нийт хөрөнгөд эзлэх %	
				2023.Н1	2024.Н1
Урт хугацаат өр төлбөр	15,042.8	26,749.6	78%	33%	44%
Урт хугацаат зээл	14,787.6	20,050.6	36%	33%	33%
Нөөц өр төлбөр	0.0	6,449.5		0%	11%
Хойшлогдсон татварын өр	0.0	92.3		0%	0%
Бусад урт хугацаат өр төлбөр	255.2	157.2	-38%	1%	0%
Эздийн өмч	18,398.2	23,366.0	27%	41%	38%
Өмч - Хувьцаат	2,318.2	2,318.2	0%	5%	4%
Нэмж төлөгдсөн капитал	6,835.7	6,835.7	0%	15%	11%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	410.9	3,377.8	722%	1%	6%
Хуримтлагдсан ашиг	8,833.4	10,834.3	23%	20%	18%

Орлого үр дүнгийн тайлан

Үзүүлэлт /сая.төг/	2023.Н1	2024.Н1	Өөрчлөлт %	Борлуулалтад эзлэх %	
				2023.Н1	2024.Н1
Борлуулалтын орлого (цэвэр)	16,460.4	17,503.9	6%	100.0%	100.0%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	8,669.2	9,210.1	6%	52.7%	52.6%
Нийт ашиг (алдагдал)	7,791.2	8,293.7	6%	47.3%	47.4%
Бусад орлого	24.4	145.2	495%	0.1%	0.8%
Борлуулалт, маркетингийн зардал	3,641.7	4,177.8	15%	22.1%	23.9%
Ерөнхий ба удирдлагын зардал	1,517.3	1,992.3	31%	9.2%	11.4%
Санхүүгийн зардал	186.2	518.2	178%	1.1%	3.0%
Бусад зардал	91.1	119.1	31%	0.6%	0.7%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-35.1	-1.1	-97%	-0.2%	0.0%
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,344.2	1,630.3	-30%	14.2%	9.3%
Орлогын албан татвар	255.4	177.7	-30%	1.6%	1.0%
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,088.8	1,452.7	-30%	12.7%	8.3%



Цэнэг бүтээгдэхүүний Pouch савлагааг шинэчиллээ

Хэрэглэгчдэдээ илүү хүртээмжтэй, хэрэглэхэд хялбар, ойлгомжтой байх үүднээс VITOS брэндийн Цэнэг бүтээгдэхүүн савлагаандаа шинэчлэлт хийлээ. Ийнхүү шинэчлэгдсэн савлагаанаас Цэнэг бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн он, сар, өдөр, сери дугаарыг илүү тод харах боломж бүрдэж хэрэглэгчдэд төөрөгдөл үүсэхээс сэргийлэх юм.



Уушги цэвэрлэх бэлдмэл шинээр мэндэллээ

Монос Хүнс ХК нь ардын анагаах ухаанд амьсгалын замын үйл ажиллагааг дэмжих зорилгоор хэрэглэгдэж ирсэн чихэр өвс, говийн ганга, чацаргана жимсний үр хальс зэрэг ургамлууд агуулсан Уушги цэвэрлэх бэлдмэл шинэ төрлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэн зах зээлд гаргаж байна. Агаар, орчны бохирдлоос үүдэлтэй амьсгалын замын халдварт өвчний нийт хүн амын дундах тархалт улирлын чанартай ихсэж байгаатай холбоотойгоор бэлдмэл хэлбэрт шилжүүлсэн, хэрэглэхэд илүү хялбар, таатай байдлаар сайжруулсан, POUCH савлагаатай Уушги цэвэрлэх бэлдмэлийг цэр ховхолж уушги цэвэрлэх, уушгины үрэвсэл дарж ханиалга намдаах, хатгалгааны үеийн эмчилгээ дэмжих төдийгүй биеийн дархлаа дэмжих зорилгоор хэрэглэх юм.



Эрүүл мэндийн хүнсний үйлдвэр ашиглалтад орлоо

Монос Хүнс ХК нь 2021 онд MFC 1.0 төслийг хэрэгжүүлж шингэн хүнсний үйлдвэрийн хүчин чадлаа нэмж үйл ажиллагаагаа өргөжүүлсэн нь манай компанийн түүхэнд тэмдэглэгдэх үйл явдал болж байсан бол үүний дараагаар бид 2022 онд MFC 2.0 төслөө эхлүүлж байсан билээ. Тэгвэл 2024 онд бид MFC 2.0 төслөө 90 гаруй хувьтай амжилттай хэрэгжүүлж Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрээ ашиглалтад оруулаад байна. Хан-Уул дүүрэг, Үйлдвэрийн баруун бүсэд байрлах 6000 гаруй кв талбайтай Монос Хүнс ХК-ийн Эрүүл мэндийн хүнсний үйлдвэр ийнхүү ашиглалтад орсноор ойрын ирээдүйд томоохон өгөөжөө авчрах MFC 2.0 төсөл бүрэн хэрэгжих боломж бүрдэж байна.


- ✓ 260 гаруй ажилтны гал тогоо
- ✓ Дундын оффис
- ✓ Сэтгэл зүйн, Амралтын, Фитнессийн, ганцаарчилсан уулзалтын өрөө
- ✓ Жижиг, том, хурлын танхим
- ✓ Лаборатори
- ✓ Ажилтнуудын хувцас солих өрөө зэрэг ажиллах орчинг тав тухтай бүрдүүлсэн орчин
- ✓ Шингэн болон хуурай хүнсний үйлдвэр
- ✓ Үйлдвэрийн агуулах
- ✓ Бариа заслын өрөө




ESG | БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ

“Эх дэлхийгээ хайрлаж, эрүүл амьдралыг хамтдаа бүтээнэ” хэмээх алсын хараатай Монос Хүнс Хувьцаат компани нь эрүүл мэндийг дэмжих хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаандаа Байгаль орчин, нийгэм, засаглалын тогтолцоог хэрэгжүүлдэг, үнэлдэг байгууллага юм. Бид эрүүл мэндийг дэмжих бүх бүтээгдэхүүнүүдээ байгаль орчинд ээлтэйгээр инноваци шингээн үйлдвэрлэдэг, бидний үйл ажиллагаа үргэлж эерэг соёлыг түгээж хүрээлэн буй орчноо хамгаалж, оролцогч талуудаа хүндэлсэн байдаг.

Монос Хүнс ХК 2023 онд үйл ажиллагааныхаа Байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд хийж хэрэгжүүлж буй ажлаа үнэлүүлж тогтолцоогоо улам батжуулан хэрэгжүүлж байна.



Бид **бүтээгдэхүүний сав баглаа боодлоос үүдэх хаягдлыг 90** хүртэлх хувиар бууруулсан.



Монос Хүнс Хувьцаат компани нь **эрчим хүчний хэрэглээгээ** өмнөх жилээс 17 хувь хэмнэн ажиллаж байгаа бөгөөд эрчим хүчний хэрэглээгээ багасгахын тулд үйлдвэр оффисын хэмжээнд **эрчим хүчний зарцуулалт багатай тоног төхөөрөмжүүдийг ашиглаж байна.**

- ✓ Үйлдвэрийн ээлжийн системийг цахилгаан хэмнэх байдлаар оновчтой болгож тоног төхөөрөмжүүдээ инвертерээр тоноглов.
- ✓ Монос Хүнс ХК-ийн хэмжээнд ашиглаж буй хөргүүр, хөргөгч, лед гэрэлтүүлэг зэрэг нь эрчим хүчний хэмнэлт бүхий А+ ангиллын хэрэгслүүд байна. Мөн бид үйлдвэрлэлээс гарах саарал усыг ашиглах талаар санал санаачилгыг гарган хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна.
- ✓ Өдөр тутамдаа үйлдвэр оффисоос гарах хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадлыг нийт ажилтнууддаа хэвшүүлэхээр олон төрлийн идэвх санаачилга гарган үр дүнтэй ажиллаж байна.
- ✓ Монос Хүнс компанийн хэрэгжүүлж буй байгаль орчин, нийгмийн чиглэлийн үйл ажиллагаа нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн дараах зорилтууд хэрэгжилтэд хувь нэмэр оруулж байна. Үүнд:

3	4	5	6	7	8	9	10	12	13	16
ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ	ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ	ЖЕНДЕВИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ	БАТАЛГААТ УНДНЫ УС АРИУН ЦӨВРИЙН БАЙРУУЛАМЖААР ХАНГАХ	СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИЙГ НЭВТРҮҮЛЭХ	ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ОСӨЛТИЙГ ДЭМЖИХ	ИННОВАЦИ БОЛОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ	ТЭГШ БҮС БАЙДЛЫГ БҮИРҮҮЛЭХ	ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ	УРГАМБЕГАЛЫН ЭВЭРЧЛЭЛТИЙН ҮР НӨЛӨӨГ БААСГАХ	ЭНХ ТАЙВАН, ШУДАРГА ЕСЫГ ЦӨГЦӨӨХ

Байгальд ээлтэй үйлдвэрлэл										
Эрүүл мэндийн боловсролыг дэмжих үйл ажиллагаа										
Хүний нөөцийн водлого										
Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа										
Ил тод байдал										

Бид ирэх 10 жил илүү алсыг харсан эх дэлхийдээ ээлтэй орших дэлхийн нийтийн уриалгад нэгдэж 2024 онд алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлээ шинэчилж эрүүл мэндийг дэмжих хүнсний үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа олон улстай хөл нийлүүлэхээр зорьж байна.



ТӨВ ОФФИС:
Монос Хүнс ХК-ийн Үйлдвэр, Сонсголонгийн
зам гудамж, 32/3 тоот, Үйлдвэрийн баруун бүс,
БГД, 20-р хороо, Улаанбаатар, 16103, Монгол улс

 www.monosfoods.mn

 foods@monos.mn



 MonosFoods

 976- 7777-3525

ХАГАС ЖИЛ, УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН /маягт 2/

<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</p>	
<p>Тайлагнах хугацаа /2 дугаар улирал, эхний хагас жил/ 2024 оны 01 дүгээр сарын 01 өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 30 өдрийг хүртэл</p>	
<p>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</p>	<p>"МОНОС ХҮНС" ХК /MFC/ улсын бүртгэлийн дугаар 9010002005, регистрийн дугаар 5568927, утасны дугаар 7777-3525</p>
<p>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</p>	<p>Монголын хөрөнгийн бирж</p>
<p>Бизнесийн үйл ажиллагааны салбар</p>	<p>Хүнсний үйлдвэр</p>
<p>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</p>	<p>408,850,428</p>
<p>Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн, хянасан албан тушаалтан</p>	<p>Гүйцэтгэх захирал А.Отгондарь</p>
<p>1</p>	<p>2024 оны хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</p>
<p>Санхүүгийн байдлын үзүүлэлт</p>	<p>Тайланг цаасаар хэвлэн, тамгаар баталгаажуулан хавсаргав</p>
<p>Орлогын тайлан</p>	<p>Тайланг цаасаар хэвлэн, тамгаар баталгаажуулан хавсаргав</p>
<p>Өмчийн өөрчлөлтийн тайлан</p>	<p>Тайланг цаасаар хэвлэн, тамгаар баталгаажуулан хавсаргав</p>
<p>Мөнгөн гүйлгээний тайлан</p>	<p>Тайланг цаасаар хэвлэн, тамгаар баталгаажуулан хавсаргав</p>
<p>2</p>	<p>Эхний хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</p>
<p>Төлөөлөн Удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны гишүүд "Монос хүнс" ХК-ийн 2024 оны 2 дугаар улирлын болон эхний хагас жилийн санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлантай танилцан хэлэлцсэн. Аудитын хорооны гишүүдийн дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, дүрэм, журам, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна гэсэн дүгнэлтийг гаргаад байгаа юм.</p>	

3	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<p>Борлуулалтын орлого эхний хагас жилийн байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 6%-ийн өссөн. Цэвэр ашгийн хэмжээ өнгөрсөн оноос 30% буурахад санхүүжилтийн зардал 178% өссөн нь голлох нөлөөг үзүүллээ.</p> <p>Нийт ашгийн түвшин 47.4% Цэвэр ашгийн түвшин 8.3% Нийт хөрөнгийн өгөөж 2.4% Эздийн өмчийн өгөөж 6.2%</p>
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	<p>Эргэлтийн харьцаа 2.4 Түргэн хөрвөх харьцаа 1.8 Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө 38% Өр төлбөр/Нийт хөрөнгө 62%</p>
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Шингэн хүнсний үйлдвэрийн хүчин чадлыг 2.5 дахин нэмэгдүүлэх, хуурай болон шингэн хүнсний үйлдвэрийг нэг байршилд нэгтгэх зорилготой "MFC 2.0" төслийн гүйцэтгэл 95%-тай байна. Барилгын ажил дууссан бөгөөд тоног төхөөрөмжийн ажил 90%-тай үргэлжилж байна.
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэсэн ажил гүйлгээ байхгүй.
4	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол, зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	2024 оны эхний хагас жилд Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан их хэмжээний хэлцэл хийгдээгүй, мөн хуулийн 89 дүгээр зүйлд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосон шийдвэрийг 2024-06-27-ны өдрийн 07 тоот тогтоолоор гаргасан байна. Уг тогтоолоор Монос хүнс ХК-ийн хамааралтай компани болох "Эм Эн Эс Жи" ХХК-ийн эзэмшлийн Сонгинохайрхан дүүргийн 20-р хороо Сонсголонгийн зам дагуу байрлах, нэгж талбарын 1801500464 дугаартай 4 газраас 1.5 га талбайтай газрыг 1,4 тэрбум төгрөгөөр үнэлэн "Монос хүнс" ХК-ийн агуулах барих зориулалтаар худалдан авахыг зөвшөөрч, компанийг төлөөлөн гэрээ хэлцэл хийх эрхийг гүйцэтгэх удирдлагад өгсөн шийдвэрийг уг хэлцэлд хамааралгүй, сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн хараат бус гишүүдийн гарын үсгээр баталгаажуулсан.	
5	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
	Тайланг өмнө тайлагнасан	

6	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл
	<p>2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үеэр ТУЗ-ийн гишүүдийг Компанийн тухай хуулийн 77.4-д зааснаар кумулятив аргаар сонгож хараат бус 3, ердийн 6, нийт 9 гишүүнийг томилсон, ТУЗ-ийн дэргэд Аудитын хороо (АХ), Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо (ЦУНДХ), Стратеги, бизнес хөгжлийн хороо (СБХХ) гэсэн 3 хороотой, ТУЗ-ийн даргаар Х.Ананд, хараат бус гишүүдээр Б.Гантулга (ЦУНДХ дарга, СБХХ гишүүн, АХ гишүүн), О.Лхагвасүрэн (АХ дарга, СБХХ гишүүн), Д.Энхтүвшин (СБХХ дарга, ЦУНДХ гишүүн), ердийн гишүүдээр Л.Хүрэлбаатар, Х.Солонго, Ц.Цэцэгбадам, Ч.Баттогтох, А.Отгондарь гэсэн 9 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд зааснаар ТУЗ-ийн ээлжит хурал улиралд 1 удаа, ээлжит бус хурлыг хуульд заасны дагуу тухайн үед зарлан хуралдуулдаг. 2024 оны эхний хагас жилийн байдлаар ТУЗ нь өмнөх оны 4 дүгээр улирлын ээлжит хурлыг 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдөр хуралдуулсан. Мөн 2024 оны 05 дугаар сарын 09 өдөр ээлжит, 2024 оны 06 дугаар сарын 26 өдөр ээлжит бус хурлыг танхим, цахим хослуулсан байдлаар хуралдуулсан. 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэн батласан. Хурлаар батлагдсан дүрмийг СЗХ болон УБЕГ зэрэг эрх бүхий байгууллагаар хянуулан бүртгүүлж хүчин төгөлдөр байдлыг ханган мөрдөж байна. Монос хүнс ХК нь СЗХ-оос батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-т зарчимд компанийн засаглалыг нийцүүлэх үүднээс ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тоог 2-оор нэмэгдүүлж нийт хараат бус 5 гишүүнтэй байхаар дүрмийн 7.2-т тусгасан. Энэхүү заалтыг хэрэгжүүлэх үүднээс 6 дугаар сарын 5-ны өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл хугацаанд ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтын зарыг нээлттэйгээр байршуулсан. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо эхний шалгаруулалтыг хийж байгаа бөгөөд ТУЗ-ийн хурлыг удахгүй хийж ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудлыг хэлэлцэх Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахаар товлож байна.</p>
7	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл
	<p>Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд зааснаар "Монос хүнс" ХК-ийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд ээлжит хурлыг жилдээ 1 удаа хуралдуулж байгаа. Компанийн 2023 оны санхүү үйл ажиллагаа хэлэлцэх хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 20 өдөр Баянгол дүүрэг, Үйлдвэрийн баруун бүс, Сонсголонгийн зам гудамж хаягт байрлах Монос хүнс ХК-ийн Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрийн шинэ барилгын 3 давхарт байрлах хурлын танхимд хуралдуулсан. Компани хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нартаа шинээр барьсан "MFC 2.0" төслийн гүйцэтгэл, шинээр барьсан үйлдвэртээ танилцах боломж олгох үүднээс хурлаа энэ байрлалд зохион байгуулсан. Монос хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн тоо 10 мянга давсан учир энэхүү танхимаар зохион байгуулж байгаа хурлыг вэб хуудас, Монос хүнс ХК-ийн фэйсбүүк групп зэрэг сувгаар шууд дамжуулалт хийн хурлыг мэдээллийг түгээж, хувьцаа эзэмшигчдээ мэдээлэл авах боломжийг цахимаар бүрдүүлж ажилласан юм. Хуралд танхим, цахимаар нийт 408,850,428 ширхэг хувьцаанаас саналын эрхтэй 305,935,435 ширхэг хувьцаа буюу 74,84%-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсон тул хурлыг хуульд заасан хүчин төгөлдөрт тооцож хуралдуулан, хурлаар хэлэлцэх асуудлуудыг шийдвэрлэж тогтоол шийдвэрийг гаргасан. Хурлаас гарсан шийдвэр болон хурлын үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг материалыг хуульд заасан хугацаанд Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлж ажилласан.</p>
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
	Овог нэр: Агаандорж овогтой Отгондарь
	Албан тушаал: "Монос хүнс" ХК-ийн Гүйцэтгэх захирал
	Гарын үсэг: 
	(Тамга/тэмдэг)
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
	Овог, нэр: Нацаг овогтой Цагаанхүү
	Албан тушаал: "Монос хүнс" ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
	Гарын үсэг: 

Сангийн сайдын 2012 оны
.....дүгээр тушаалын
.... дугаар хавсралт

Регистрийн дугаар:

5	5	6	8	9	2	7
---	---	---	---	---	---	---

Хаяг: Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 205/2

Шуудангын хаяг:

Утас: 77773525

Факс: 11-343525

Өмчийн Хэлбэр: ХК

Төрийн ... Хувь

Хувийн хувь



"МОНОС ХҮНС" ХК
2024 ОНЫ 2-Р УЛИРЛЫН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Хянаж хүлээн авсан байгууллагын нэр	Сар, өдөр	Гарын үсэг

Санхүүгийн байдлын тайлан

Монос хүнс ХК

(Аж ахуйн нэгжийн нэр)

2024 оны 06 сарын 30 өдөр

/төгрөгөөр/

2023.12.31

2024.06.30

ХӨРӨНГӨ

Эргэлтийн хөрөнгө	2023.12.31	2024.06.30
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	27,537,478,725.73	6,746,535,041.55
Дансны авлага	3,956,881,152.33	5,536,270,786.30
Татвар, НДШ - ийн авлага	2,174,902,729.74	1,921,637,966.23
Урьдчилж төлсөн татвар	2,174,902,729.74	1,921,637,966.23
Урьдчилж төлсөн даатгал	-	-
Бусад авлага	155,898,950.41	224,082,089.88
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
Бараа материал	4,944,922,170.59	6,831,719,323.42
Бараа	1,085,059,770.83	1,997,841,009.75
Түүхий эд материал	3,230,096,097.33	4,386,400,869.32
Хангамжийн материал	431,434,616.73	447,477,444.36
Дуусаагүй үйлдвэрлэл	-	0.00
Агентад байгаа бараа	-	-
Замд яваа бараа	198,331,685.71	-
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	393,107,144.89	412,098,854.20
Урьдчилж төлсөн зардал	152,965,823.76	76,591,348.44
Урьдчилж төлсөн тооцоо	240,141,321.12	335,507,505.75
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бу	-	4,084,158,688.43
Нийт Эргэлтийн хөрөнгө	39,163,190,873.69	25,756,502,750.01
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	37,399,888,885.06	34,184,627,426.29
Биет бус хөрөнгө	414,045,069.65	377,534,165.08
Биологийн хөрөнгө	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	76,129,571.34	98,706,400.73
Бусад эргэлтийн бус хөрөнгө	283,210,938.04	382,012,775.97
Нийт Эргэлтийн бус хөрөнгө	38,173,274,464.09	35,042,880,768.07
Нийт ХӨРӨНГӨ	77,336,465,337.78	60,799,383,518.08

ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ

Өр төлбөр	2023.12.31	2024.06.30
Богино хугацаат өр төлбөр	19,484,477,030.52	10,683,767,957.02
Дансны өглөг	1,079,640,204.43	1,679,041,047.77
Цалингийн өглөг	164,472,880.00	132,972,880.00
Татварын өр	1,688,054,915.53	614,561,936.90

НДШ-ийн өглөг	151,542,740.16	189,913,198.70
Богино хугацаат зээл	15,184,920,000.00	7,089,960,000.01
Зээлийн хүүгийн өглөг	249,479,832.44	68,102,235.59
Ногдол ашгийн өглөг	-	-
Урьдчилж орсон орлого	48,499,204.42	103,986,635.87
Нөөц өр төлбөр	211,013,841.60	211,013,841.60
Бусад богино хугацаат өр төлбөр	706,853,411.93	594,216,180.58
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бу	-	-
Урт хугацаат өр төлбөр	35,845,809,142.09	26,749,571,499.82
Урт хугацаат зээл	29,025,579,664.00	20,050,579,664.00
Нөөц өр төлбөр	6,449,500,336.00	6,449,500,336.00
Хойшлогдсон татварын өр	213,517,809.29	92,280,167.02
Бусад урт хугацаат өр төлбөр	157,211,332.79	157,211,332.79
Нийт Өр төлбөр	55,330,286,172.61	37,433,339,456.83
Эздийн өмч		
Өмч - Төрийн	-	-
Өмч - Хувийн	-	-
Өмч - Хувьцаат	2,318,181,926.76	2,318,181,926.76
Халаасны хувьцаа	-	-
Нэмж төлөгдсөн капитал	6,835,733,063.19	6,835,733,063.19
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,508,104,274.29	3,377,825,059.09
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
Хуримтлагдсан ашиг	10,344,159,900.94	10,834,304,012.21
Нийт Эздийн өмч	22,006,179,165.17	23,366,044,061.25
Нийт ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	77,336,465,337.78	60,799,383,518.08

Гүйцэтгэх захирал

(А. Отгондарь)

Санхүү хариуцсан захирал

(Ц. Дэлгэрмаа)



Орлогын дэлгэрэнгүй тайлан

Монос хүнс ХК
(Аж ахуйн нэгжийн нэр)

2024 оны 06 сарын 30 өдөр
/төгсгөөр/

	2023.06.30	2024.06.30
Орлого үр дүн		
Борлуулалтын орлого (цэвэр)	16,460,408,160.12	17,503,850,516.44
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	8,669,197,046.59	9,210,137,973.41
Нийт ашиг (алдагдал)	7,791,211,113.53	8,293,712,543.04
Хүүний орлого	3,351,800.72	105,432,825.63
Ногдол ашгийн орлого	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого	21,026,518.88	39,726,171.38
Борлуулалт, маркетингийн зардал	3,641,744,631.42	4,177,848,170.80
Ерөнхий ба удирдлагын зардал	1,517,326,273.24	1,992,275,617.20
Санхүүгийн зардал	186,164,215.21	518,162,581.32
Бусад зардал	91,083,615.00	119,116,617.81
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(35,102,545.95)	(1,124,072.44)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,344,168,152.30	1,630,344,480.47
Орлогын албан татвар	255,385,909.85	177,671,167.96
Татварын дараах ашиг (алдагдал)	2,088,782,242.45	1,452,673,312.51
Зогсоосон үйл ажиллагааны татвар	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,088,782,242.45	1,452,673,312.51
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Нийт Орлого үр дүн	2,088,782,242.45	1,452,673,312.51

Гүйцэтгэх захирал

(А. Отгондарь)

Санхүү хариуцсан захирал

(Ц. Дэлгэрмаа)



ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Монос хүнс ХК
(Аж ахуйн нэгжийн нэр)

2024 оны 06 сарын 30 өдөр
/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	2,318,181,926.76	0.00	6,835,733,063.19	410,914,484.64	0.00	0.00	7,725,833,099.36	17,290,662,573.94
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	2,318,181,926.76	0.00	6,835,733,063.19	410,914,484.64	0.00	0.00	7,725,833,099.36	17,290,662,573.94
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	3,480,290,196.43	3,480,290,196.43
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	-981,241,027.20	-981,241,027.20
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	2,097,189,789.65	0.00	0.00	119,277,632.35	2,216,467,422.00
9	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2,318,181,926.76	0.00	6,835,733,063.19	2,508,104,274.29	0.00	0.00	10,344,159,900.94	22,006,179,165.17
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	2,318,181,926.76	0.00	6,835,733,063.19	2,508,104,274.29	0.00	0.00	10,344,159,900.94	22,006,179,165.17
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	1,452,673,312.51	1,452,673,312.51
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	-92,808,416.43	0.00	0.00	0.00	-92,808,416.43
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	962,529,201.23	0.00	0.00	-962,529,201.23	0.00
17	2024 оны 06 сарын 30-ний үлдэгдэл	2,318,181,926.76	0.00	6,835,733,063.19	3,377,825,059.09	0.00	0.00	10,834,304,012.21	23,366,044,061.25

Гүйцэтгэх захирал

(А. Отгондарь)

Санхүү хариуцсан захирал

(Ц. Дэлгэрмаа)



Мөнгөн гүйлгээний тайлан

Монос хүнс ХК

(Аж ахуйн нэгжийн нэр)

2024 оны 06 сарын 30 өдөр

/төгрөгөөр/

2023.06.30

2024.06.30

Бүх цэвэр мөнгөн гүйлгээ

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Мөнгөн орлогын дүн (+)

Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	16,181,300,889.18	17,434,794,846.94
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,620,963.00	-
Буцаан авсан албан татвар	-	201,491,963.40
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	5,663,339.02	171,213,614.29
Нийт Мөнгөн орлогын дүн (+)	16,188,585,191.20	17,807,500,424.62

Мөнгөн зарлагын дүн (-)

Ажиллагчдад төлсөн	(2,578,388,545.03)	(3,436,646,811.50)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(918,428,184.43)	(1,063,106,302.32)
Бараа материал худалдан авахад төлсөн	(5,233,302,040.47)	(8,107,376,324.35)
Ашиглалтын зардалд төлсөн	(286,237,387.68)	(332,071,150.67)
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(340,148,311.73)	(494,658,503.92)
Хүүний төлбөрт төлсөн	(1,243,176,419.12)	(1,668,432,558.32)
Татварын байгууллагад төлсөн	(2,541,601,658.40)	(2,855,716,897.98)
Даатгалын төлбөрт төлсөн	(71,156,284.40)	(78,903,293.31)
Бусад мөнгөн зарлага	(2,251,720,439.06)	(2,672,798,152.70)
Нийт Мөнгөн зарлагын дүн (-)	(15,464,159,270.31)	(20,709,709,995.08)

Нийт Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

724,425,920.88 (2,902,209,570.45)

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Мөнгөн орлогын дүн (+)

Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1,800,000.00	3,000,000.00
Хүлээн авсан хүүний орлого	-	-
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
Нийт Мөнгөн орлогын дүн (+)	1,800,000.00	3,000,000.00

Мөнгөн зарлагын дүн (-)

Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(7,222,515,490.46)	(812,749,359.87)
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	(4,300,000.00)
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-

Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
Нийт Мөнгөн зарлагын дүн (-)	(7,222,515,490.46)	(817,049,359.87)
Нийт Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(7,220,715,490.46)	(814,049,359.87)

Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Мөнгөн орлогын дүн (+)		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	10,366,121,439.13	9,681,364,035.00
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Төрөл бүрийн хандив	-	-
Нийт Мөнгөн орлогын дүн (+)	10,366,121,439.13	9,681,364,035.00
Мөнгөн зарлагын дүн (-)		
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	(3,574,607,190.29)	(26,751,324,034.99)
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	-	-
Нийт Мөнгөн зарлагын дүн (-)	(3,574,607,190.29)	(26,751,324,034.99)
Нийт Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	6,791,514,248.84	(17,069,959,999.99)

Валютын ханшийн зөрүү	(4,399,276.29)	(4,724,753.87)
Нийт Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	290,825,402.97	(20,790,943,684.18)

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	295,523,503.11	27,537,478,725.73
---	-----------------------	--------------------------

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	586,348,906.08	6,746,535,041.55
--	-----------------------	-------------------------

Гүйцэтгэх захирал

(А. Отгондарь)

Санхүү хариуцсан захирал

(Ц. Дэлгэрмаа)

